МОНГОЛ УЛС
ЁС ЗҮЙН ХОРОО


Ажлын алба

# БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭ

Ёс зүйн хорооны 2026 оны 03 дугаар тогтоол

2026 ОН

# Тогтоолын хавсралт



МОНГОЛ УЛС
ЁС ЗҮЙН ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 07 сарын 06 өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

Байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.1, 11.6.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2024 оны "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай" 27 дугаар тогтоолын 3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.5 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгууллагын "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийг нэгдүгээр, "Үнэлгээ хийх аргачлал, хамрах хүрээ, дараалал"-ыг хоёрдугаар, "Тайлангийн маягт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус батлагдсугай.

2.Батлагдсан шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу тайланг салбар, нэгжийн түвшинд нэгтгэн жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнахыг төрийн болон нутгийн захиргааны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг мэргэшил, арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж, нэгдсэн дүнг жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Ёс зүйн хороонд танилцуулахыг Ажлын алба (Н.Ганбаатар)-нд даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Ёс зүйн хорооны "Шалгуур үзүүлэлт батлах тухай" 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.АМАРТӨГС

ХАВСРАЛТ I

Байгууллагын "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"

- ✓ Ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаа-3Ш/Ү-3
- ✓ Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал-5Ш/Ү-4
- ✓ Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа-4Ш/Ү-3
- ✓ Үр дүн

ХАВСРАЛТ II

"Үнэлгээ хийх аргачлал, хамрах хүрээ, дараалал"

- ✓ Үндэслэл, зорилго, зорилт, зарчим
- ✓ Хамрах хүрээ, дараалал
- ✓ Үнэлгээний аргачлал
- ✓ Баталгаажуулалт

ХАВСРАЛТ III

Тайлангийн маягт

- ✓ Товч танилцуулга (хууль тогтоомжийн хэрэгжилт)
- ✓ Дүгнэлт
- ✓ Баталгаажуулалт

# I. Ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаа

| № | Агуулга | Шалгуур үзүүлэлт | Үр дүн |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаа (ЁЗЗУССГҮХ) | Байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (нөлөөллийн аян, хэлэлцүүлэг, өдөрлөг, уралдаан, сайн туршлага түгээх гэх мэт) бүтээлч ажлын тоо | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын соёлын зөрчил орчин төлөвшихөд ахиц гарна. |
| 2 | | Батлагдсан сургалтын агуулгын хүрээнд тухайн жилд 2-оос доошгүй зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан нийт албан хаагчийн хувь | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн талаар мэдлэг ойлголт дээшилж, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх хандлага төлөвшинө. |
| 3 | | Байгууллагын эрсдэлийн үнэлгээний түвшин (хамрагдсан хувиар) | Ёс зүйн эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт сайжирч, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. |


| Шалгуур | Нотолгоо | Оноо | Үнэлэх гол нөхцөл |
|---|---|---|---|
| Бүтээлч, нөлөөллийн ажлын тоо | Удирдамж, тушаал, тайлан | 1 | 4 ба түүнээс дээш-1 оноо,<br>3 бол 0.8 оноо;<br>2 бол 0.5 оноо;<br>1 бол-0.2 оноо;<br>0 бол 0 оноо.<br>*(улирал бүр 1 бүтээлч ажлаар тооцно)* |
| Жилд 2-оос доошгүй сургалтад хамрагдсан албан хаагчийн хувь | Хамрагдалт-ын бүртгэл | 1 | (2 ба түүнээс дээш сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо÷**нийт албан хаагчийн тоо**)×100= хэрэгжилтийн хувь<br>90–100%-1 оноо;<br>80–89%-0.8 оноо;<br>60–79%-0.5 оноо;<br>40–59%-0.2 оноо;<br>40%-иас доош бол-0 оноо. |
| Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан салбар, нэгжийн хувь | Эрсдэлийн үнэлгээний тайлан | 1 | (Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан салбар, нэгжийн тоо÷**үнэлгээнд хамрагдах нийт салбар, нэгжийн тоо**)×1= хэрэгжилтийн оноо. |

# II. Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ) | Удирдах албан тушаалтнуудын ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдсан хувь | Удирдах албан тушаалтны ёс зүйт манлайлал, хариуцлага дээшилнэ. |
| 5 | | Ёс зүйн дэд хорооны гишүүдийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа (сургалт, урамшуулал, баталгаа) | Байгууллагын Ёс зүйн дэд хорооны чадавх дээшилнэ. |
| 6 | | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний тогтвортой ажиллагаа | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн хараат бус, тогтвортой, үр нөлөөтэй ажиллах нөхцөл бүрдэнэ. |
| 7 | | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийн дагуу ёс зүйн зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн хувь | Ёс зүйн зөрчилд хариуцлага тооцох механизм сайжирч, шийдвэрийн хэрэгжилт, сахилга хариуцлага дээшилнэ. |
| 8 | | Нийтэд ил тод байршуулсан Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлан, ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн тоо | Мэдээллийн ил тод байдал сайжирч, иргэдийн төрд итгэх итгэлийг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ. |

| | | |
|---|---|---|
| Удирдах албан тушаалтны сургалтын хамрагдалт | 0.5 | (Сургалтад хамрагдсан удирдах албан тушаалтны **тоо÷нийт удирдах албан тушаалтны тоо**)×0.5= хэрэгжилтийн оноо |
| Дэд хорооны гишүүдийн чадавх | 1 | Сургалт зохион байгуулсан бол 0.3 оноо;<br>урамшууллыг бүрэн олгосон бол 0.4 оноо;<br>нийгмийн баталгаагаар хангасан бол 0.3 оноо. |
| Дэд хорооны бүрэлдэхүүний тогтвортой байдал | 0.5 | Шинээр томилогдсон болон чөлөөлөгдсөн гишүүдийн тоо÷**тайлант хугацааны эхний байдлаар нийт гишүүдийн тоо**)×100=өөрчлөлтийн хувь<br>0–20% 0.5 оноо;<br>21–40% 0.4 оноо;<br>41–60% 0.3 оноо;<br>61–80% 0.2 оноо;<br>80%-иас дээш 0 оноо. |
| Дүгнэлтийн дагуу хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн хувь | 1 | (Хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн тоо÷**ёс зүйн дэд хорооны гаргасан нийт дүгнэлтийн тоо**)×1= хэрэгжилтийн оноо<br>*(гомдол, мэдээлэл ирээгүй бол 1 оноо)* |
| Үйл ажиллагааны тайлан, хариуцлагын шийдвэрийг нийтэд байршуулсан байдал | 1 | Дэд хорооны үйл ажиллагааны тайланг нийтэд байршуулсан бол 0.5 оноо;<br>хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг нийтэд байршуулсан бол 0.5 оноо;<br>үгүй бол 0 оноо. |

# III. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа



| | | | |
|---|---|---|---|
| 9 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ) | Ёс зүйн дэд хорооны гишүүдийн зохион байгуулсан зөвлөгөө, мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо | Төрийн албан хаагчдын Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдэж, ёс зүйн зөрчил гарах эрсдэл буурна. |
| 10 | | Ёс зүйн асуудлаар ирүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлт (дүгнэлт)-ийн хувь | Хуульд заасан хугацаанд шуурхай, шударга шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ. |
| 11 | | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг эс зөвшөөрч гаргасан гомдлын тоо | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтэд хяналт тавьж, Төрийн албан хаагчийн эрхийг хангах боломж бүрдэнэ. |
| 12 | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийн ашиглалт, дүгнэлт, шийдвэрийн бүртгэл, тайлагналт | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын нэгдсэн цахим сан бүрдэж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг цахимаар төлөвлөн, тайлагнаж, ажил хөнгөвчилнө. |

| | | |
|---|---|---|
| Зөвлөгөө, мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо | 0.5 | 4 ба түүнээс дээш 0.5 оноо;<br>3 арга хэмжээ-0.4 оноо;<br>2 арга хэмжээ 0.3 оноо;<br>1 арга хэмжээ-0.2 оноо;<br>0 бол 0 оноо.<br>*(улирал бүр 1 арга хэмжээгээр тооцно)* |
| Гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь | 1.0 | (Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн тоо÷**нийт ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо**)×1=хэрэгжилтийн оноо<br>*(гомдол, мэдээлэл ирээгүй бол 1 оноо)* |
| Дэд хорооны дүгнэлтийг эс зөвшөөрсөн гомдлын хувь | 1.0 | Дүгнэлтийг эс зөвшөөрсөн гомдлын тоо÷**нийт дүгнэлтийн тоо**)×100=<br>хэрэгжилтийн хувь<br>0–20% 1 оноо;<br>21–40% 0.7 оноо;<br>41–60% 0.5 оноо;<br>61–80% 0.3 оноо;<br>80%-иас дээш 0 оноо.<br>*(гомдол, мэдээлэл ирээгүй бол 1 оноо)* |
| Бүртгэл, хяналтын дэд системийн ашиглалт, бүртгэл, тайлагнал | 0.5 | Дэд системийн ашиглалт бүрэн бол 0.5;<br>дутуу бол 0.3;<br>хангалтгүй бол 0 оноо. |

# Үнэлгээний дүнг нэгтгэх

| № | Төв байгууллага | Нэгтгэх хамрах хүрээ |
|---|---|---|
| 1 | Ерөнхийлөгчийн Тамгын газар | Шууд харьяалах бусад байгууллага |
| 2 | УИХ-ын Тамгын газар | Шууд харьяалах бусад байгууллага |
| 3 | УИХ-аас бүрэлдэхүүн, удирдлагыг сонгож, томилдог байгууллага | Аймаг, нийслэл, орон нутгийн нэгж, салбар болон шууд харьяалах байгууллага |
| 4 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | Шууд харьяалах бусад байгууллага |
| 5 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар | Шууд харьяалах бусад байгууллага |
| 6 | Төрийн захиргааны төв байгууллага /яамд/ | Агентлагаас бусад шууд харьяалах салбар, нэгж болон төрийн бусад байгууллага |
| 7 | Засгийн газрын агентлаг | Орон нутгийн нэгж, байгууллага, шууд харьяалах байгууллагууд |
| 8 | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Эрхлэх асуудлын хүрээний байгууллага, сумын **ЗДТГ /ЗГ-ын 2025 оны 37 тогтоол/** |
| 9 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Дүүргийн ЗДТГ, шууд харьяалах салбар, нэгж **/ЗГ-ын 2024 оны 81, 2025 оны 35/** |

# Үнэлгээний дараалал

**БАЙГУУЛЛАГА /ЯАМ, АГЕНТЛАГ Г.М/** Шууд харьяалах салбар, нэгжээс ирүүлсэн үнэлгээ, тайланд үндэслэн нэгдсэн үнэлгээ хийж, ЁЗХ-нд илгээх

**САЛБАР, НЭГЖ**
Үйл ажиллагаа, нотолгоонд суурилан өөрийн үнэлгээг хийж, дээд шатны байгууллагад илгээх




**АЖЛЫН АЛБА**
94 байгууллагаас ирүүлсэн үнэлгээ, тайланд дүн шинжилгээ, үнэлгээ хийж, ЁЗХ-нд танилцуулах

Тайлагнал ба үнэлгээний дараалал

**ЁС ЗҮЙН ХОРОО**
Үнэлгээний дүнтэй танилцаж, холбогдох шийдвэр гаргах

**АЖЛЫН АЛБА**
Дүнг ЗГХХГ-т хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх, тайланг цахим хуудсанд байршуулах

# Баталгаажуулалт, хяналт

01 Нотолгоогүй үр дүнд оноо өгөхгүй

02 Хугацаа хэтэрсэн тайланд чанар, бүрэн байдлыг харгалзана

03 Ёс зүйн гомдол, мэдээлэл гараагүй бол автоматаар бүрэн оноо өгөхөөс өмнө бүртгэл, тайлангийн баталгаажуулалтыг системээс шалгана

04 Нэг үйл ажиллагааг олон шалгуурт давхар тооцохгүй

05 Ноцтой зөрчил, олон нийтийн итгэлд нөлөөлсөн үйл явдлыг тайлагнаагүй бол оноо бууруулна

06 Байгууллагын үнэлгээ /94/ дэд системийн үнэлгээнээс 1-ээс дээш оноогоор зөрвөл тайлбар, нотолгооны нэмэлт тулгалт хийж, эцсийн оноог баталгаажуулна

07 Ажлын алба дэд системийн мэдээлэл, баримт оруулах арга зүйн зөвлөгөө өгнө

# Тайлангийн маягт



| Тайлангийн хэсэг | Оруулах мэдээлэл |
|---|---|
| Нэг. Товч танилцуулга | Байгууллага, хамрах хүрээ, тайлант хугацааны үндсэн мэдээлэл |
| 2.1. Тогтолцоог бэхжүүлэх | Бүтээлч ажил, сургалт, эрсдэлийн үнэлгээ |
| 2.2. Ёс зүйн манлайлал | Удирдлагын сургалт, дэд хорооны чадавх, тогтвортой байдал, хариуцлага, ил тод байдал |
| 2.3. Дэд хорооны үйл ажиллагаа | Зөвлөгөө, гомдол шийдвэрлэлт, эс зөвшөөрсөн гомдол, дэд системийн ашиглалт |
| Дүгнэлт | Ололт амжилт, бэрхшээл, санал |
| Баталгаажуулалт | Томилох эрх бүхий албан тушаалтан, дэд хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг |

**Шалгах хэсэг: Аргачлалын дагуу үнэлсэн эсэх, төлөвлөгөө ба хэрэгжилтийн тайлан, эрсдэлийн үнэлгээ, маягтын бүрэн байдал**

# Давуу тал, тайлангийн хугацаа

## Давуу тал

- Онооны бүтэц, босго, нотолгоог тодорхой заасан.
- Байгууллагын удирдлагын ёс зүйн манлайллыг илүү өргөн хүрээтэй хэмжиж, үнэлэх боломж бүрдсэн.
- Ёс зүйн дэд хорооны чадавхыг бэхжүүлэх чиглэлийг үнэлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх нөхцөл бүрдсэн.
- Цахим бүртгэлтэй тулгалт хийх хяналтын механизмыг бий болсон.
- Ижил түвшний байгууллагын хууль тогтоомжийн хэрэгжилтийг жил бүр харьцуулан дүгнэх боломж бүрдсэн.

## Тайлан

- Салбар, нэгжийн түвшинд нэгтгэн жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор /94 байгууллага тайлангаа /
- Нэгдсэн дүнг жил бүрийн 03.01-ний дотор /Ёс зүйн хороонд танилцуулна/
- ЗГХХГ-т /Дараа оны 03.15-ны дотор хүргүүлнэ/
- ТАХЁЗТХ-19.4 /Тайланг ил тод байршуулна/

**Үнэлгээний үр дүнд байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагын тогтолцоог сайжруулах удирдлагын хэрэгсэл болгох**

Ажлын албаны
Захиргаа, эрх зүйн хэлтэс

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА